

*Хууль сахиулахын удирд.чагын академийн
8042 дугаар дамжааны суралцагч Удирдахуйн ухааны
магистрант дэд хурандаа Б.Буянням
Buyannyab.B.Master of law enforcement leadership executive academy*

ХИЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛД ТАЛ ХЭЭРИЙН БҮСИЙН ХИЛ ХАМГААЛАЛТЫН УДИРДЛАГЫН ОРОЛЦОО, ЗАРИМ АСУУДАЛ

Түлхүүр үг: Монгол улс, төр, бодлого, хил, хилийн аюулгүй байдал, хилийн зурвас, бүс.

Keywords: Mongolia, government, policy, border, border security, border lane.

Оршил

"Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна" ¹ гэж Үндсэн хуульд зааснаар, зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Монгол Улсын оршин тогтносон 2200 гаруй жилийн хугацаанд нутаг дэвсгэр хил, хязгаарын төлөө явуулсан тэмцлийн түүхээс харахад түүнд тал бүрээс учирч байсан аюул занал нь түүнийг хүн төрөлхтний түүхийн тавцангаас зайлуулах, нутаг дэвсгэрийг нь эзэмших, эс чадваас хил орчмын тодорхой газар нутгийг таслаж авах зорилго, чиглэлтэй явагдаж иржээ².

Энэ нь Хүн ам цөөн, газар нутаг өргөн уудам, нийгэм эдийн засгийн хөгжлөөр харьцангуй сул манай улсын хувьд өөрийн аюулгүй байдлыг хангахад нэн түрүүнд улсын хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангах нөхцөл бүрдүүлэх явдал юм гэдгийг өнгөрсөн үеийн түүхэн сургамж харуулж байна. 70 гаруй жилийн өмнө Японы милитаристуудын зүгээс Халхын голын чиглэлээр өдөөсөн дайны зорилго нь Монголын талаас эзэмшилгүй байсан хил орчмын газар нутгийг цэргийн хүчээр, дээрмийн аргаар эзэмшихийн төлөө явагдсаныг бид мартаагүй байна.

Өнөөдөр хөдөөгийн хүн амын ихэнх нь төврүүтээ нүүдэллэж олонх нь нийслэлд амьдрах болсноор хил орчмын нутаг дэвсгэр эзэнгүйрч байна.

¹ Үндэсний аюулгүй байдлын тухай хууль. Төрийн мэдээлэл сэтгүүл №28/963. УБ., 2001.

Жекей Х. "Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь". УБ., 2004. 38. дах тал.

Экологийн нөхцөл байдалд нүүрлэж буй цөлжилт говийн бүсийг төдийгүй тал хээр, ойт хээрийн бүс нутгийг хамарч байгаагаас хүн амын амьдрал ахуйд нөлөөлж, хилийн дагуу асар уудам газар нутаг эзэнгүйрч улсын хил хамгаалалтад шууд нөлөөлөх болов.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн ээдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг айл зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм.

Монгол Улс нь Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улстай улсын хилийн асуудлыг XX зууны сүүлийн хагаст бүрэн шийдвэрлэж, баталгаажилтыг нь хүлээн зөвшөөрснөөр олон улсын эрх зүйн үндэс бүрдсэн байна. Цаашид тогтоон тэмдэглэж, баталгаажсан хилийг өөрчлөхгүй, зөрчилгүй, олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн хамгаалах ажиллагааг улам боловсронгуй болгох нь манай хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг болж байна.

Улсын хилийг хамгаалах талаар хууль эрх зүйн орчин бүрдэж, Монгол улсын хилийн тухай хуульд бүлэгчилэн тодорхой тусгаж өгсөнөөр хилийн аюулгүй байдлын талаар баримтлах эрх зүйн үндэслэлтэй болсон.


Олон улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлыг хилийн орон зай (хил, хилийн зурвас, бүс, хил орчмын нутаг дэвсгэр)-д төр, нийгэм, иргэдийн язгуур ашиг сонирхол баталгаатай хамгаалагдсан байх нөхцөлийг хэлдэг бөгөөд хилийн аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болдог байна¹. Гэж тэмдэглэсэн байна.

Зорилго: Хилийн аюулгүй байдлын тухай ерөнхий ойлголт өгөх, хууль эрх зүйн талаас нь тайлбарлах, тал хээрийн бүсийн хил хамгаалалтын удирдлагын зарим аргыг тодорхойлох

Сэдвийг томъёолох нь: Хилийн аюулгүй байдал гэдэг нь "улсын хил, хил орчмын нутаг дэвсгэр, (хилийн орон зай)-д үндэсний аюулгүй байдал найдвартай хангагдах гадаад, дотоод нөхцөл баталгаатай хангагдах явдал"² гэж манай эрдэмтэд үздэг билээ.

¹ Монгол улсын хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл №06/963”. УБ., 2017.

² Жекей Х. "Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь". УБ., 2004. 38. дах тал.



бүсчилсэн хил хамгаалалтад шилжинэ гэдэг нь хилийн аюулгүй байдлын салашгүй нэг хэсэг тэр тусмаа улсын хил хамгаалах байгууллагад хил хамгаалах урлаг, түүний дотор хилийн цэргийн опериативын урлагийг хөгжүүлэх онол практикийн олон талт асуудлыг шийдвэрлэнэ гэсэн үгээр энэ хүү өгүүллээ эхэлж байна.

Үндсэн хэсэг: Судлаач миний бие хил, хязгаарыг тайлбарласан нэр томьёог хурандаа Д.Дашдаваа багшийн түүвэрлэн тайлбарласан хэсгээс иш татасан болно. Хил хязгаарын тухай уламжлалт мэдлэг, ойлголт, өөрийн гэсэн нэр томьёотой. Жишээ нь:

Нутгийн зах: Тухайн нутаг дэвсгэр, аливаа бэлчээрийн хязгаарыг тодорхой уул, овоо, гол мөрнөөр багцаалан нэрийдэх.

Нутгийн дээс: Нутгийн захыг газар дээр нь тогтоосон шугам, тодотгол. Нутгийн захыг тодорхой хэмжээс бүхий дээсээр хэмжиж тодорхойлж байснаас үүдэлтэй нэр томьёо.

Нутгийн овоо: Нутгийн захыг овоо босгон тэмдэглэх заншлаас улбаатай нэр томьёо. Ихэвчлэн чулуу, модон овоо байсан. Модонд бичиг сийлж голд нь хатах, нутаг нийлэх талууд модонд бичиг бичиж олонд мэдэгдэлгүйгээр булж нуух зэргээр баталгаажуулж байсан хилийн тэмдэг.

Нутгийн зааг: Монголын нутаг дэвсгэрийн заагийн зургийг анхлан манай эриний 46 онд үйлдэх сурвалж бий. Газрын зургийг даавуу, торго, арьс зэрэг дээр зурдаг байсан.

Нутгийн цэс: Аливаа эзэмшлийн, өөрөөр хэлбэл хошуудын газар нутгийн хэмжээ, дотоод хуваарь, захын овоодын хоорондох зай, зүг чиг, дугаар, аль талаараа ямар нутагтай зах нийлэх зэргийг нарийвчлан бичсэн тэмдэглэл.

Хилийн цэс: Одоогийн орон нутгийн засаг захиргааны нэгж нийслэл, аймаг, сум, дүүргийн нутаг дэвсгэрийн захыг тогтоосон нэр томьёо.

Хүн төрөлхтний түүхэнд улсын хилийн асуудлаар улс гүрний хаад, төр засаглагч, эрдэмтэн мэргэд онолын үзэл баримтлалуудыг номлож, энэ нь соёл иргэншил, дайн ба энхийн асуудлаас шууд хамааралтайгаар хүний нийгмийн түүхэн үйл явцад төр улс орших, эс оршихуйг тодорхойлогч гол хүчин зүйл нь хилийн аюулгүй байдал байсаар л ирсэн¹. Дээрх тайлбаруудаас харахад хил гэдэг үгийг газар нутгийн зах хязгаарыг заагласан шугам, түүний орчим газрыг илэрхийлсэн утгаар тайлбарласан байна.

“Аюулгүй байдал” гэдэг ерөнхий ойлголтыг Я.Цэвэлийн тайлбар толь: “аймаар юмгүй, айх болгоомжлох шаардлагагүй”, “аюулгүй байдал гэдэг бол аюулгүй, бүрэн бүтэн байх, найдвартай, итгэлтэй байх”^{1 2} гэж тайлбарлажээ.

“Хилийн аюулгүй байдал” гэж улсын хил, хил орчмын нутаг дэвсгэрт улс, нийгэм, иргэдийн язгуур эрх ашиг сонирхлыг хангах, гадаад, дотоод таатай нөхцөл баталгаатай хангагдсан байхыг хэлнэ³.

Монгол Улсын оршин тогтнохуйн бүхий л хугацаанд хил хязгаар гэсэн ухагдахуун төрийн бодлогын байнгын анхааралд байж, түүний хамгаалалт нь ямагт улс төр, дипломатын, цэргийн дэглэмийн арга хэмжээгээр голлон хэрэгжиж ирсэн болно. 1962 оноос хойд хилд, 1979 оноос хилийн шугамын хамгаалалт дагнасан байдалтай байгаад 2002 онд Монгол Улсын Их Хурлын тогтоолоор Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого⁴ батлагдан гарч хил хязгаарын аюулгүй байдлын хамгаалалтын шинэ үе эхэлсэн гэж хэлж болхоор байна.

Аливаа улсын хил нь нийгэм, улс төрийн эдрээтэй бодит үзэгдэл мөн бөгөөд түүнийг зэргэлдээ орших улсуудын төрийн эрх барих дээд байгууллагатай хамтран шийдвэрлэж, хоёр улсын болон олон улсын эрх зүйн баримтаар баталгаажуулан хэрэгжүүлдэг онцлогтой юм⁵,

“Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, улсын хил халдашгүй дархан байна”⁶ гэж Үндсэн хуульд зааснаар, зэргэлдээх улсуудтайгаа сайн хөршийн нөхөрсөг харилцаа тогтоож, дэлхийн улс бүхэнтэй олон улсын эрх тэгш, нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримтлан нээлттэй харилцах гадаад бодлого баримталж байна.

Улсын Их Хурлаас баталсан “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого” баримт бичигт “Хилийн талаар баримтлах бодлого нь

¹ Дашдаваа Д. “Улсын хилийн аюулгүй байдлын зарим асуудал”. УБ., 2014. 20 дах тал

² Цэвэл Я. “Монгол хэлний товч тайлбар толь”. УБ., 1966. 60 дах тал

³ Монгол улсын хилийн тухай хууль. “Төрийн мэдээлэл сэтгүүл №06/963” 5-2т. УБ., 2017

⁴ Арвай Ш. “Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого. стратегийн онцлог”. УБ., 2015. 9 дах тал.

⁵ Арвай Ш. “Улсын хилийн тухай дурсамж, үзэл бодол”. УБ. 2005. 35 дах тал.

⁶ Монгол Улсын үндсэн хууль. Цахим эх сурвалж, холбоос. Legalinto.mn

байгууллага. иргэдийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулах замаар улсын хилийн халдашгүй байдал, хил орчмын нутаг дэвсгэрийн аюулгүй байдлыг хангахад чиглэнэ”¹ гэж заасан. Энэ нь хилийн аюулгүй байдлыг агуулгын хувьд бүрэн хамарч чадаагүй байна.

Хилийн аюулгүй байдал нь Монгол Улсын төрийн, орон нутгийн засаг захиргааны болон төрийн бус байгууллагууд хилийн болон хил орчмын нутаг дэвсгэрт өөрсдийн эрх мэдлийн хүрээнд улс төр, эрх зүйн, дипломатын, батлан хамгаалах, цэргийн, тагнуулын, оператив-эрлийн, гаалийн, экологийн, хүн-мал эмнэлгийн ба бусад арга хэмжээг нэгдмэл бодлоготой, харилцан уялдаатай явуулах зэрэг үйл ажиллагаагаар хангагдана*². Гэж зассан нь хилийн аюулгүй байдлын ерөнхий ойлголт, хангах арга зам, чиглэлийг нь тодорхойлж байгаа юм.

Хилийн аюулгүй байдлыг хангах гол асуудал нь хилийн орчинд Монгол Улсын үндэсний язгуур ашиг сонирхлыг гадаад, дотоодын аюул, заналаас хамгаалах төр, нийгэм, иргэний аюулгүй байдлыг хангахдаа юуны урьд хилийн талаар байгуулсан олон улсын гэрээ хэлэлцээр, эрх зүйн хэм хэмжээг сахих, зэргэлдээ улстай хамтын ажиллагааг хөгжүүлэх бүх талын бололцоо олгоход гол зүйл юм.

Товчоор хэлэхэд хилийн аюулгүй байдал гэдэг нь зөвхөн гадны улсын түрэмгийллээс улс орны хил хязгаарыг хамгаалах бус олон улсын алан хядагчид, хууль бусаар цагаачлагчид, хар тамхи, хүнийг хууль бусаар хил нэвтрүүлэх, бусад үндэстэн дамнасан гэмт хэрэгтнүүд тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэхээс сэргийлэх зэрэг илүү өргөн утгыг илэрхийлдэг. Судалгаанаас үзэхэд:

Дийлэнх хөгжсөн орнууд улсын хилээ дараах гурван шалтгаанаар хамгаалдаг байна. Үүнд:

1. Дотоодын хуулийн дагуу үл хүсэх гадаадын иргэдийг (гэмт хэрэгтнүүд, хар тамхины наймаачид, алан хядагчид гэх мэт) тухайн улсын нутаг дэвсгэрт нэвтрэхээс сэргийлэх

2. Татвар хураамж авах, гаалийн хууль тогтоомж зөрчигчдийг илрүүлэх, шийтгэх, хууль бус барааг хураах

3. Хортой, эрүүл бус, эрүүл ахуйн шаардлага хангахгүй жимс, ногоо, ургамал, амьтнаас халдварт өвчин дэлгэрэхээс сэргийлэх³ зэрэг шалтгаанууд орно. Үүнээс үзэхэд хилийн аюулгүй байдал гэдэг нь хөгжсөн орнуудын хувьд хууль бусаар хүн хил нэвтрэх явдлыг таслан зогсоох, гаалийн хяналт шалгалтыг

Арвай Ш. “Монгол улсын төрөөс улсын хилийн талаар баримтлах бодлого, стратегийн онцлог”. УБ., 2015.15 дах тал.

² Төртогтох Т. “Улсын хилийн аюулгүй байдал”. УБ., 2004. 54 дах тал.

³ Дашдаваа Д. “Улсын хилийн аюулгүй байдлын зарим асуудал”. УБ., 2014. 25 дах тал

явуулах, эрүүл ахуй, мал эмнэлэгийн холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээнүүд байдаг гэдэг нь харагдаж байна.

Бүсчилсэн хамгаалалтад шилжсэнээр хилийн аюулгүй байдал хэрхэн хангагдах талаар нь авч үзвэл:

Монгол Улсын хэл зүйн тайлбар толь бичигт *"Бүс нутаг"* гэдэг нь нутаг дэвсгэрийн аль нэг таксономийн нэгж болдоггүй нэлээд том хэмжээний нутаг дэвсгэр гэж тодорхойлсон байдаг.

Таксоном гэдэг нь: Ерөнхий шинж чанар бүтцийн хувьд нэгдсэн бүлэг ангилал бүхий объектуудын нэгдэл юм. Газарзүй, хэл шинжлэл, биологийн шинжлэх ухаанд ихэвчлэн хэрэглэгддэг¹.

Монгол Улсын хэл зүйн тайлбар толь бичигт. Удирдах үйл ажиллагааг: Улсын бол тархи, уулсын бол оргил, гэрээр бол тооно гэж тайлбарласан байна.

Мөн Удирдах үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэгч нь удирдлагын байр^{1 2} (байлдаанд бэлтгэн түүнийг зохион байгуулан, удирдах захирагч, штабын офицеруудын хамтын үйл ажиллагаа гэж ойлгож болно)

Бүс нутгийн тухай ойлголтыг, газар зүйн шинжлэх ухааны судалгааны чиглэл болох байгалийн нөхцөл, нөөц, нийгэм түүний хэрэгцээ, үйлдвэрлэх хүчний харилцаан дахь нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын тухай³ онолын хүрээнд авч үздэг байна.

Манай улстай зах нийлэн хиллэдэг ОХУ, БНХАУ улсууд нь цэрэг-улс төр, нийгэм, эдийн засаг, хөгжлийнхөө байр сууриараа дэлхийд тэргүүлэгч улс гүрнүүдийн тоонд зүй ёсоор тооцогддог.

Монгол Улсын физик газар зүйн онцлогийг үндэслэн улсын хил хамгаалалтыг говь цөлийн, тал хээрийн, ой тайгын, уулын бүсийн гэж ангилсан боловч өнөөгийн байдлаар тэр нь бодит байдал дээр тохирсон цаг хугацаатайгаа уялдсан, хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах шаардлагад нийцэхгүй байна.

Тал хээрийн бүс: Далайн түвшингээс дээш 550-1200 метр өндөрт өргөгдсөн Дорнод Монголын тал нутаг, Халх, Нөмрөгийн дархан цаазат газрын А бүсүүд, тусгай хэрэгцээний газрууд бүхий Сүхбаатар аймгийн Баяндэлгэр, Онгон, Дарьганга, Наран, Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Халх гол, Матад, Баянтүмэн, Чойбалсан. Чулуунхороот, Дашбалбар, Баяндун, Баян-Уул зэрэг 2 аймгийн 13 сумын нутаг дэвсгэр, хилийн бүс зурваст хилийн анги, салбарын хариуцсан 1857.3 км хэсэг буюу улсын хилийн 22.5 хувь хамрагдана⁴ гэж үзсэн нь бүсчилсэн байдлаар удирдах хэрэгцээ шаардлага байгааг тодорхойлж байна.

¹ Цэвэл Я. "Монгол хэлний товч тайлбар толь". УБ., 1966. 56. дах тал.

² Цэвэл Я. "Монгол хэлний товч тайлбар толь". УБ., 1966. 16. дах тал.

³ Хадхүү Ё. "Тал хээрийн бүсийн хил хамгаалалтын онцлог". УБ., 2012. 9. дах тал.

⁴ Хадхүү Ё. "Тал хээрийн бүсийн хил хамгаалалтын онцлог". УБ., 2012. 10. дах тал.

Байгаль цаг уурын онцлог нь: Тэгш тал, элсэн манхан, уул, толгод, гуу жалга, гол, горхи, нуур, намаг, хусан ойтой. үржил шим сайтай хөрстэй, ургамлын гарц малын бэлчээр сайн боловч сүүлийн жилүүдэд Сүхбаатар аймгийн өмнөд хилийн хэсгээр цөлжилт эрчимтэй явагдаж байна.

Зуны улиралд 30-35 хэм хүртэл халж, өвөлдөө 25-30 хэм хүртэл хүйтэрдэг жилд дунджаар 100-150 мм хур тунадас унадаг. хаврын улиралд шороон шуурга шуурдаг.

Дэд бүтцийн хувьд: Хилийн ангиуд нь төв суурин газарт байрладаг, хилийн салбарууд цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй, хилийн анги салбарууд нь хооронд дунджаар 25-300 км зайтай бөгөөд хилийн дагуух зам харгуй бартаа саад багатай. "Хилийн бүс зурваст оршин суугчид, ажил үйлдвэр эрхлэгчдийн нягтрал нэмэгдэх хандлагатай" ¹ . Гэж судласан нь хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлон гаргах гол тулгуур болж байгаа юм.

Хил хамгаалалтад нөлөөлөх хүчин зүйл:

Эерэг тал нь:

Нэг цэгээс хяналт явуулах, хүч хэрэгслийн шилжилт хөдөлгөөн үйлдэх боломж өндөр;

Улсын хил хамгаалалтыг суурин болон хөдөлгөөнт харуулаар хамгаалах боломжтой;

Инженерийн байгууламжийг хил хамгаалалтад ашиглах боломж ихтэй;

- Хил хамгаалалтад агт уналга, тээврийн хэрэгсэл ашиглах боломжтой;

Мал аж ахуй, туслах аж ахуй, газар тариалан хөгжүүлэхэд тохиромжтой.

Бүсийн сургалтын төвүүд байгуулан хүний нөөцийг мэргэшүүлэх боломжтой

Сөрөг тал нь:

Өнгөлөн далдлалтыг зохион байгуулах боломж харьцангуй муу;

Цасан болон шороон шуургатай үед цэргийн хяналт хийх боломж хязгаарлагдмал;

Байгалийн онц аюултай үзэгдлүүд, хээрийн түймэр их гардаг.

Жекей Х. "Оршин тогтнохын аюулгүй байдлыг хангах бодлогын хүрээнд улсын хил хязгаар, нутгийн хамгаалалтыг боловсронгуй болгох нь". УБ., 2004. 38. дах тал.

Уул уурхай, ашигт малтмал зэрэг үйл ажиллагаа явуулах нэрийн доор гадны хөрөнгө оруулалттай компани нэмэгдхийн хирээр хил орчмын дэглэмийн зөрчил, байгаль экологи. хүн амын удмын сангийн эсрэг аюулгүй байдалд нөлөөлөх хэмжээний эрсдэлтэй.

Тал хээрийн бүсийн хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах эрх зүйн үндэс нь: Монгол Улсын хилийн тухай хууль, Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол улсын засгийн газраас 2012-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Бүсчилсэн хамгаалалт”-ын талаар тусгагдсан зүйл заалт, Хууль Зүй Дотоод Хэргийн Сайдаар батлагдсан “Дархан хил хөтөлбөр”, Монгол Улсын Их хурлын 2001 оны 57 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал зэрэг эрх зүйн баримт бичигт нь үндсэн тулгуур баримт бичгүүд болно.

Улсын хил хамгаалалтыг улс орны хэмжээнд удирдан зохион байгуулах үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага, ХХЕГ түүний харьяа хилийн анги, салбарууд бөгөөд одоогийн үүсэж байгаа цагийн байдал, нийгэм, эдийн засгийн өсөлт, бууралт, гадаадын хөрөнгө оруулалт нэрийн дор үүсэж байгаа их хэмжээний бэлэн мөнгөний эргэлт зэрэг нь бус нутгийн өнөөгийн байдалд маш хүчтэй нөлөөлж болзошгүй байгаа билээ.

Түүгээр ч зогсохгүй хил залгаа улсын хилийн нөхцөл байдал, хил хамгаалалтын тогтолцоо, манай улсын талаар баримталж буй гадаад бодлого, харилцаа-хамтын ажиллагааны чиг хандлагыг хамтад нь авч үзэж болох юм.


Ийм ч учраас хилийн цагийн байдал, хилийн аюулгүй байдлыг хангах, хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах үеийн “орчин” гэж үзэж бүс нутаг, улс орны хэмжээнд авч үзэх шаардлагатай бөгөөд хил хамгаалалтын дүрэм, журамд хилийн цагийн байдал, “орчин” гэх мэт асуудлыг тусгайлан авч үзэж зохицуулалт хийх нь чухал гэдгийг тэмдэглэж байна.

Аливаа улс өөрийн хил хязгаар газар нутгаа ямар нэгэн хэлбэрээр заавал хамгаалдаг онцлогтой. Улсын хил нь халдашгүй дархан байх олон шинж чанар агуулдаг. Өнөө үед улсын хилийн талаар дэлхий нийтийн баримтлаж буй нийтлэг зарчим бол:

Нэгдүгээрт Олон улсын жишигт нийцэж тохирсон хилийн боомтуудыг олшруулж, зорчигчид, тээврийн хэрэгсэл, ачаа барааны хяналт үйлчилгээг шуурхай боловсронгуй болгох.

Хоёрдугаарт Гарц боомтгүй бусад хэсгийг хилийн зөрчил будлианд хүргэхгүй байх төвшинд хамгаалах асуудлыг зэвсэг хэрэглэсэн, хүчээр түрий барьсан аргаар шийдвэрлэхээс татгалзах, инженер техникийн, хилийн төлөөлөгчийн, тагнуулын хүч хэрэгсэл, хууль эрх зүйн орчины хүрээнд илэрхийлэгдэж байна.

Монгол Улсын хил хамгаалалтын дүрэмд:




Үүнээс үзвэл хил хамгаалалт гэдэг нь дээр дурдсан арга хэмжээнүүдийн нэгдмэл цогц ¹ болох учир эдгээрийг ямар хэрэгсэл ашиглаж, яаж хэрэгжүүлэхээс ихээхэн шалтгаалах нь тодорхойгүй байгаа билээ.

Монгол улс хоёр хөрштэйгөө найрамдал, хамтын ажиллагааны тухай тэгш эрхтэй гэрээ байгуулж сайн хөршийн зарчим баримталж байна.

Монгол улсын хил бүрэн тогтоон тэмдэглэгдэж, хилийн дэглэмийн талаар хоёр тал үүрэг хариуцлага хүлээсэн хууль эрхийн олон улсын гэрээ байгуулж мөрдөж байна.

Хилийн халдашгүй дархан байдлын хүрээнд бус нутгийн хил хамгаалалтыг удирдан зохион байгуулах нэгдсэн нэг зохион байгуулалт, удирдлага байх нь зүйн ёсны шаардлага байгаа юм.

¹ Монгол улсын хилийн тухай хууль. Төрийн мэдээлэл № 06/963. УБ., 2017 он.



Хил хамгаалалтыг хэлбэрүүдээр зохион байгуулна¹. Гэж заасан бөгөөд удирдах арга зүйн нь **захиргааны** зарчимаар зохион байгуулан удирдах нь зүй ёсны хэрэг юм.

Жишээ нь: Хил хамгаалах байгууллагуудын үйл ажиллагааг зохион байгуулан удирдахдаа Хил хамгаалалтыг удирдах төрийн захиргааны байгууллага нь хэтийн, дунд, ойрын хугацааны болон үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр, хилийн ангиуд нь ойрын хугацааны болон жилийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөө, хилийн салбарууд нь жил, сарын төлөвлөгөөнүүдийг тус тус боловсруулж мөрдөнө. Гэж хил хамгаалалтын дүрмээр зааж өгсөн байна.

Энэ нь тал хээрийн бүсийн хил хамгаалалтыг зохион байгуулан удирдах үйл ажиллагааны хувьд ямар аргаар явуулах вэ? Гэдэг асуулдад захиргааны арга гэж шууд тодорхойлж болхоор байгаа юм.

Хилийн нэр томьёоны тайлбар тольд Захиргаа гэдэг нь: нэг талаас хууль тогтоох болон шүүх эрх мэдлээс бусад төрийн байгууллагын удирдлагын, түүний гүйцэтгэн захирамжлах үйл ажиллагаа.

Нөгөө талаас гүйцэтгэх эрх мэдлийн хэрэгжүүлэгч байгууллагын нэр^{1 2} гэж тайлбарласан байна.

Мөн захиргааны байгууллага гэж Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн засагласан шийдвэр гаргадаг, төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага, түүнчлэн засгийн газрын байгууллагын зарим үүргийг төлөөлөн гүйцэтгэдэг засгийн газрын бус байгууллага, хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан шийдвэр гаргаж, нийтийн үйлчилгээ үзүүлдэг сургууль, эмнэлэг, холбоо, харилцаа, эрчим хүч зэрэг байгууллагын захиргаа, нутгийн өөрөө удирдах ёсны болон шашны

¹ Хил хамгаалалтын дүрэм. УБ., 2006.

² Ганболд М. "Хилийн нэр томьёоны тайлбар толь". УБ., 2010. 106. дах тал.

байгууллага зэрэг нийтийн эрх зүйн субъект болох байгууллага ¹ . Гэж тэмдэглэсэн байна.

Тал хээрийн бүсийн хил хамгаалалтыг зохион байгуулж удирдах захиргааны арга нь дараах зарчим дээр суурылгана гэж үзэж байна.

1 .Хил хамгаалах байгууллагын үндсэн чиг үүргийг дээдлэх;

2 .Тал хээрийн бүс нутгийн нийгэм, соёлын харьцангуй жигд хөгжлийг хангахад чиглэсэн нэгдмэл орчныг бүрдүүлэх;

3 .Тал хээрийн бүсийн хилийн аюулгүй байдал. эрүүл мэнд. соёл, боловсролын үйлчилгээг тухайн бүс дотор нь аймаг, орон нутгийн чадавхид түшиглэн хилчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

4 .Тал хээрийн бүсийн хил хамгаалалтад орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжүүдийн хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоог бэхжүүлж, тэдгээрийн дэмжилгийг оновчтой зохион байгуулах;

б .Нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрхийг хүндэтгэх, тэдгээрийн онцгой бүрэн эрхэд хамаарах асуудалд хөндлөнгөөс үл оролцох;

б .Хүний нөөцийг мэргэшүүлэх, тусгай мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэх, бүс нутгийн эдийн засгийн өсөлтөд дэмжлэг үзүүлж, мэргэжил үйлдвэрлэлийн сургалт явуулах зэрэг бий болгож болох юм.

Дүгнэлт

Хилийн аюулгүй байдлын тухай ойлголтыг нэгтгэн дүгнэхэд: Хилийн орон зайд явагддаг бүх харилцаа хамардаг учир түүнийг зөв ойлгож, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг, хүний наймаа, мансууруулах бодисын зөөвөр, цөмийн түүхий эд материал дамжуулан худалдаалах, үйлдвэрлэх оролдлого, байгалийн гамшигт үзэгдэл, дэлхийн цаг уурын дулаарал, хүний амьдрах орчны бохирдол, нэн халдварт өвчний тархалт, олныг хамарсан ядуурал, эмх замбараагүй дүрвэлт, олон улсын терроризмтай тэмцэх, урьдчилан сэргийлэх таслан зогсоох арга хэмжээ нь хилийн аюулгүй байдлын тухай ойлгот гэж дүгнэж болно.

Хилийн аюулгүй байдал нь: төр, нийгэм, иргэдийн язгуур эрх ашгийг хилийн орчинд хангах замаар үндэсний, улс хоорондын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ.

Хилийн аюулгүй байдлын агуулга нь хилийн орчны үндэсний язгуур ашиг сонирхол, эдгээрт учруулж болзошгүй аюул занал, түүнээс хамгаалах талаар хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоонд чиглэсэн үйл ажиллагаагаар илэрхийлэгдэнэ гэж дүгнэж байна.

Тал хээрийн бүс нь Монгол Улсын стратегийн болон оперативын чиглэл бөгөөд газар нутаг, байгалийн баялаг, хүн амын шилжилт хөдөлгөөний

¹ Ганболд М. “Хилийн нэр томъёоны тайлбар толь”. УБ., 2010. 107. дах тал.

өнөөгийн байдал зэргээс үндэслэн тал хээрийн бүсэд хил хамгаалалтыг удирдах, нэгдсэн удирдлага бий болгох хэрэгцээ шаардлага байгаа гэдгийг тэмдэглэх нь зүй ёс юм.

Иймд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хилийн цагийн байдлын өрнөлт, түүний дотроос улсын хил зөрчигчдийн үйл ажиллагаа зохион байгуулалттай хэлбэрт шилжиж, улсын хилийг өөрсдийн гэмт үйлдлийг хэрэгжүүлэх объектоо болгон сонгон авч, орчин үеийн өндөр хүчин чадлын автомашин, холбоо дохиоллын хэрэгслээр орон нутаг, цаг хугацааг товчлох болсон энэ цаг үед тал хээрийн бүсийн хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах нэгдсэн удирдлага бий болгох

2. Тал хээрийн бүсийн хяналтын нэгдсэн тогтолцоонд шилжих, инженер техникийн төхөөрөмжөөр тоноглох

3. Монгол Улсын Хилийн төлөөлөгчийн үйл ажиллагааг өргөтгөх, тусдаа бие даасан газрын хэмжээнд зохион байгуулах

4. Тагнуул гүйцэтгэх ажлын хүч хэрэгслийг улсын хил хамгаалалтад оролцуулах гэмт үйлдлийг таслан зогсоох

5. Хил хамгаалалтын бүх төрлийн хангалтыг тухайн бүс нутгийн онцлогт тохируулан зохион байгуулах

6. Шинжлэх ухаан технологийн ололтод суурилсан шинэ техник технологийг улсын хил хамгаалалтад нэвтрүүлж, хөрш орныхоо болон олон улсын жишигт нийцүүлэх

7. Тал хээрийн бүсийн хил хамгаалах байгууллагын байгуулалтыг боловсронгуй болгож бүсчилсэн хил хамгаалалтыг зохион байгуулан, удирдлагыг оновчтой, газрын статустай хуульчилан бий болгох шаардлагатай.